



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ТАРХАЛТЫН МЭДЭЭ

2018 он, Гуравдугаар улирал

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2018 оны Гуравдугаар улирлын байдлаар Номхон далайн баруун бүсийн 4 оронд хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна (Хүснэгт 1).

ХОЁР. 2003 оноос хойш бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл ба нас баралт:

2003 оноос 2018 оны Гуравдугаар улирал хүртэлх хугацаанд дэлхийн 16 улсад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын **860** тохиолдол бүртгэгдсэнээс **454** (52.7%) нь нас барсан бөгөөд сүүлийн тохиолдол 2017 оны 9-р сарын 26-нд Индонези улсад 1 тохиолдол бүртгэгдэж нас барсан байна. 2003 оноос хойш Номхон далайн баруун бүсийн 4 оронд **238** тохиолдол бүртгэгдсэнээс **134** (56%) нь нас барсан байна. Камбожи улсад нас баралтын түвшин хамгийн өндөр (66%; 37/56) байна.

Хүснэгт 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн томуугийн А (H5N1) вирусын халдварын хүний өвчлөл, нас баралт, бодит тоогоор, 2003 – 2018 оны Гуравдугаар улирал

Улс	2003-2011		2012		2013		2014		2015		2016		2017		Нийт	
	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н
Камбожи	18	16	3	3	26	14	9	4	0	0	0	0	0	0	56	37
Хятад	41	27	2	1	2	2	2	0	6	1	0	0	0	0	53	31
Лаос	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	2
Вьетнам	119	59	4	2	2	1	2	2	0	0	0	0	0	0	127	64
Нийт	180	104	9	6	30	16	13	6	6	1	0	0	0	0	238	134

Тэмдэглэгээ: (Т)-тохиолдол; (Н)-нас баралт

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2018 оны Гуравдугаар улирлын байдлаар шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн **1 шинэ тохиолдол** БНХАУ-д бүртгэгдсэн байна.

2014 оны 5-р сараас хойш БНХАУ-д лабораториор батлагдсан нийт **20** тохиолдлоос **6** (37.5%) нь нас барсан байна.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2018 оны Гуравдугаар улирлын байдлаар шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

Сүүлд 2018 оны 2-р сарын 14-нд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн анхны тохиолдол БНХАУ-ын Jiangsu мужад бүртгэгдсэн талаар ДЭМБ-аас мэдээлж байсан.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2018 оны Гуравдугаар улирлын байдлаар шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2013 оноос хойш шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн нийт **1567** тохиолдол лабораториор батлагдсан.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2018 оны Гуравдугаар улирлын байдлаар шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2015 оны 12-р сараас хойш БНХАУ-д хүний өвчлөлийн **17** тохиолдол бүртгэгдсэн байна.

ДОЛОО. Шувууны томуугийн вирусын шувууны өвчлөлийн мэдээлэл:

Хүснэгт 2.

2018 он, Гуравдугаар улирал

Улс	Өртөмхий	Үхсэн	Устгасан	Тайлбар
А (H5N6) вирусын шувууны өвчлөл				
Вьетнам	12620	1590	11030	Шувууны ферм
А (H5N2) вирусын шувууны өвчлөл				
Тайвань	210784	7844	202940	Цацагт хяруул, зүйл тодорхойгүй
А (H5N1) вирусын шувууны өвчлөл				
Малайз	2415	29	2386	Шувууны ферм
Камбожи	378	318	60	Шувууны ферм
А (H5) вирусын шувууны өвчлөл				
Тайвань	60591	235	60356	Шувууны ферм

Албан ёсны эх сурвалж:

- http://www.who.int/influenza/human_animal_interface/H5N1_cumulative_table_archives/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/EN_GIP_20140727CumulativeNumber_H5N1cases.pdf
- http://www.wpro.who.int/outbreaks_emergencies/H7N9/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/influenza_h7n9/en/index.m
- http://www.wpro.who.int/emerging_diseases/aiweekly_465_09jan2015.pdf?ua=1
- <http://empres-i.fao.org/eipws3g/#h=0>

ЗӨСҮТ

ЭУББТСТ

ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧИН ХАРИУЦСАН БАГ